

**2024 оны аймгийн Хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтэнд
ХШҮ хийсэн тухай дүгнэлт**

2024-12-02

Аймгийн ИТХ-ын 2023 оны 12 сарын 04-ний өдрийн 03 дугаар тогтоолоор баталсан Сүхбаатар аймгийн 2024 оны аймгийн хөгжлийн төлөвлөгөөний нийт салбарын 14 үр дүнгийн хүрээний 109 ажил, арга хэмжээнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийв.

Хэрэгжилт гаргах нийт арга хэмжээний тоо		109
Үр дүнтэй	100%	60
Тодорхой үр дүнд хүрсэн	90%	14
	70%	13
Эрчимжүүлэх шаардлагатай	50%	3
	30%	8
Үр дүнгүй	0%	7
Үнэлэх боломжгүй		4
Хэрэгжилтийн дундаж		81.5%

1. Салбарын үр дүн: Өвчлөл, нас баралтыг бууруулна.

11 арга хэмжээний хэрэгжилт 93,3%. 11 арга хэмжээнээс Түмэнцогт суманд баригдах 17 ортой Эрүүл мэндийн төвийн барилга, Эрдэнэцагаан суманд баригдах спорт заалны тендер төрийн Худалдан авах ажиллагааны газарт 3-5 удаа зарлагдсан боловч шалгаруулалтад компани ороогүйгээс хэрэгжээгүй ба үнэлэх боломжгүй гэж үнэлсэн.

2. Салбарын үр дүн: Боловсролын чанар хүртээмжийг нэмэгдүүлнэ.

9 арга хэмжээний хэрэгжилт 88,9. Ахмад багш нарын чуулга уулзалт зохион байгуулах арга хэмжээ 10 сард төлөвлөгдсөн ба зохион байгуулах хугацааг 10 сар буюу сонгуулийн үеэр төлөвлөсөн ба төлөвлөлтийн алдаанаас хэрэгжээгүй гэж дүгнэсэн.

3. Салбарын үр дүн: Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настанд ээлтэй орчин бүрдүүлж, жендерийн эрх тэгш байдлыг хангана.

4 арга хэмжээний хэрэгжилт 55%. Аймгийн Ахмадын бага чуулганыг зохион байгуулах арга хэмжээг зохион байгуулахаар төлөвлөсөн ба зохион байгуулаагүй, 0 үнэлгээтэй байна.

4. Салбарын үр дүн: Хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж нийгмийн баталгааг сайжруулна.

Нийт 6 арга хэмжээний хэрэгжилт 95%.

Салбарын үр дүн: Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг хөгжүүлж, эдийн засгийн эргэлтэнд оруулна.

2 арга хэмжээний хэрэгжилт 85%.

5. Салбарын үр дүн: Орон нутагт үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.

3 арга хэмжээний хэрэгжилт 100%. Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт хангалттай.

6. Салбарын үр дүн: ХАА-н салбарын бүтээмжийг нэмэгдүүлнэ.

6 арга хэмжээний хэрэгжилт 81,6%.

7. Салбарын үр дүн: Малын гоц халдварт өвчний гаралтыг бууруулна

5 арга хэмжээний хэрэгжилт 100%. Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилт хангалттай.

8. Салбарын үр дүн: Аялал жуулчлал

4 арга хэмжээний хэрэгжилт 80%.

9. Салбарын үр дүн: Боомтын хүчин чадлыг нэмэгдүүлж ачаа тээвэрлэх чадавхийг нэмэгдүүлнэ.

3 арга хэмжээний хэрэгжилт 70%.

10. Салбарын үр дүн: Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлнэ.

2 арга хэмжээний хэрэгжилт 100%.

11. Салбарын үр дүн: Хөдөөгийн сэргэлтийн хүрээнд орон нутгийг хөгжүүлэх суурь дэд бүтцийн хангамжийг нэмэгдүүлнэ.

7 арга хэмжээний хэрэгжилт 71.8%.

12. Салбарын үр дүн: Засаглалын үзүүлэлтийг сайжруулна.

12 арга хэмжээний хэрэгжилт 92,5%.

13. Салбарын үр дүн: Байгаль орчны тогтвортой байдлыг хадгална.

15 арга хэмжээний хэрэгжилт 69.2%. Усыг хуримтлуулах, зэрлэг амьтан, бэлчээрийн ус хангамжийг нэмэгдүүлэхээр хөв цөөрөм байгуулах /Баяндэлгэр сум/ ажлыг төсвийн тодотголоор хассан, Ойн менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэх арга хэмжээг Ойн газрын зөвлөмжийн дагуу хийлгээгүй гэх шалтгаанаар тус салбарын үр дүн дэх 2 арга хэмжээг үнэлэх боломжгүйгээр тооцсон.

Эрчимжүүлэх шаардлагатай буюу 30% үнэлгээтэй арга хэмжээ

- Аялал жуулчлалын гол чиглэлийн дагуу замын тэмдэг тэмдэглэгээ хийх
- Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 426.7 км төмөр зам, хилийн боомтын холболт, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барих
- Наран суманд төрийн албан хаагчдын орон сууц барих
- Дэд бүтцийн хангамжид тулгуурлан иргэнд газар өмчлүүлэх боломжтой газрын нөөцийг тогтоож газрыг өмчлүүлэх.

Үр дүнгүй буюу 0 үнэлгээтэй 8 арга хэмжээний шалтгаан

1. **Зохион байгуулалтаас:** Сүхбаатар аймгийн Байгаль орчны 2019-2023 оны тайлан хэвлүүлэх, Аймгийн Ахмадын бага чуулганыг зохион байгуулах
2. **Төлөвлөлтөөс:** Ахмад багш нарын зөвлөгөөн зохион байгуулна.
3. **Төсөв санхүүгээс:** Үерийн байгууламж барих ажлын тооцоо судалгаа зураг төсөв хийлгэх, 960 айлын орон сууцны хорооллын ажил эхлүүлэх, Хуучин Цэвэрлэх байгууламжийг үнэргүйжүүлж бордоо болгож ашиглах, Дарьганга суманд 20 га Ойн зурвасны арчилгааны ажил, Байгаль хамгаалагч нарыг чадавхижуулах смарт программын сургалт авах, сургагч багш бэлтгэх

Үнэлэх боломжгүй ажил арга хэмжээ-4/

Түмэнцогт суманд баригдах 17 ортой ЭМТ-ийн барилга, Эрдэнэцагаан суманд баригдах спорт заалны гүйцэтгэгч сонгон шалгаруулах тендерийг төрийн худалдан авах ажиллагааны газарт 4-5 удаа зарлагдсан боловч сонгон шалгаруулалтанд компани ороогүй, Баяндэлгэр суманд зэрлэг амьтан, бэлчээрийн ус хангамжийг нэмэгдүүлэхээр хөв цөөрөм байгуулах ажлыг АДАПТ төсөлтэй хамтран хийхээр төлөвлөсөн ч төслөөс зураг төсвийн ажил хийгдээгүй, Ойн менежментийн төлөвлөгөөг мэргэжлийн байгууллагаар хийлгэх арга хэмжээ нь Ойн газрын зөвлөмжийн дагуу хойшлогдсон зэрэг шалтгаануудаар хийгдээгүй тул **Үнэлэх боломжгүй** гэж тус тус үнэлсэн.